

2025/7/31

№ 25/17

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Ард Кредит ББСБ ХК-тай байгуулсан 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн ЗГ/MN730052111300148592 тоот зээлийн гэрээний хугацааг 24 сараар сунгаж, Зээлийн шугамын эрхийн хэмжээг 481,720 ам.доллараар нэмэгдүүлж 1,000,000 ам.доллар болгохыг зөвшөөрсүгэй.

2. Зээлийн шугамын эрхийг дараах нөхцөлөөр тогтоосугай.

Зээлийн хүү	12% /жилийн/
Комитмент хүү	0
Зээлийн хугацаа	24 сар
Ам.долларын ханш	Албан ханшаар тооцно.
Эргэн төлөх нөхцөл	Хугацааны эцэст үндсэн зээл хумих, сар бүр хүү төлөх

3. Зээлийн барьцаанд Компанийн эзэмшлийн Ард Даатгал ХК (MSE:AIC)-ийн 5,500,000 ширхэг хувьцааг барьцаалж, барьцааны гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Золбоо)-д олгож, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудит эрхэлсэн захирал (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ